



Г САНХҮҮ, САНГИЙН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА
С.НАРАНЦОГТ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.25 № 04/30 УАА-САА/2013/08/СТА-ТС

Г Авлага барагдуулах тухай Г

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх болон өргөтгөснөөр ажлын байр бий болгох зорилгоор малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнд жижиг зээл олгохоор Анод банкинд байршуулсан 800.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ыг үндэслэн холбогдох газарт хандаж дээрх авлагыг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулж ажиллахыг Санхүү, сангийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга С.Наранцогт, ерөнхий нягтлан бодогч Ц.Эрдэнэтөгс нарт үүрэг болгож албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлагын биелэлтийг 2013 оны 12 дугаар сарын 25-ны дотор багтаан Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

Аудитор



Д.Гандолгор

070083